

“ХАРХОРИН” ХК-ИЙН 2022 ОНЫ 04 САРЫН 23 ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 04-р сарын 23 өдөр

Хархорин сум

“Хархорин” нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04-р сарын 23-ны өдөр 14.00 цагаас Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах компанийн өөрийн байранд хурлын танхимд хуралдсан болно.

Хархорин сумын хэмжээнд Ковид цар тахал ерөнхийдөө хумигдаж, бүх нийтийн бэлэн байдлын зэргийг цуцалсан тул Хурал зохион байгуулах комиссын зүгээс хурлыг уламжлалт хэлбэрээр зохион байгуулсан. Хурлаар хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид болон бусад хүмүүсийг халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн амны масктай байх, гараа ариутгах, биеийн халуун хэмжих зэрэг арга хэмжээг авч хурлын танхимд нэвтрүүлсэн болно.

Хурал болсон газар: Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах компанийн өөрийн байр, 1 давхарт хурлын зааланд

Хурал болсон он, сар, өдөр, цаг: 2022 оны 04-р сарын 23-ний өдөр 14.00 цагаас

Хурлын даргын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: Пүрэвийн Учрал

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

“Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн ээлжит хуралд хувьцаа эзэмшигч Сүрэнжавын Пүрэв (377,660 ш хувьцаатай), Долгосүрэнгийн Дашмаа (100 ш хувьцаатай), Намхайн Рагчаа (100 ш хувьцаатай), Цэндсүрэнгийн Баасансүрэн (100 ш хувьцаатай), Чимэддоржийн Отгонсүрэн (93 ш хувьцаатай) нар оролцсон болно.

Түүнчлэн тус хурал дээр компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд ТУЗ-ийн гишүүн П.Учрал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга бөгөөд хурал зохион байгуулах комиссын дарга Б.Ганбат, Тооллогын комиссын дарга М.Шавагцэрэн, Тооллогын комиссын гишүүн Ц.Болортуяа нар байлцсан. ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Бүрэн, Б.Амарсанаа нар гар утсаараа холбогдож /чанга яригч дээр тавьж/ оролцсон болно.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Ганбат

Хурлын ирц: 70.1 хувь

Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо болон хурлын ирцийн тухай:

Хурлын бүртгэлийн өдөр буюу 2022 оны 04-р сарын 04-ний өдрөөр тасалбар болгон “ҮЦТХТ” ХХК-с гаргуулсан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй болон хураангуй судалгаагаар “Хархорин” ХК-ийн 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий нийт 581 хувьцаа эзэмшигч, эдгээр хувьцаа эзэмшигчдийн эзэмшил, өмчлөлд нийт 539,515 ш саналын эрх бүхий хувьцаа байна гэж бүртгэгдсэн. Ийнхүү нийт 581 хувьцаа эзэмшигч саналаа ирүүлэхээс саналын эрх бүхий нийт 378,053 ш энгийн хувьцаа эзэмшигч байгаа 5 хувьцаа эзэмшигч хуралд оролцож саналаа өгсөн. Хурлын ирц 70.1% болсон. Ирцийн тайлан дараах байдалтай байна:

д.д	Хуралд оролцсон, саналаа хэрхэн өгсөн	Хувьцаа эзэмшигчийн тоо	Хувьцааны тоо
1	Хуралд өөрийн биеэр хүрэлцэн ирж оролцсон	5	378,053 (70.1%)
2	Хуралд биечлэн оролцоогүй, саналаа саналын хуудсаар ирүүлсэн	0	0 (0%)
	Нийт	5	378,053 (70.1%)

Компанийн тухай хуулийн 68.4-т заасны дагуу саналын хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийг хуралд оролцсонд тооцдог тул Хурал зохион байгуулах комиссын зүгээс тус хуралд биечлэн ирж оролцох боломжгүй байгаа хувьцаа эзэмшигчдийг саналаа өгөх боломжоор хангаж, хурлын зарыг СЗХ-ны холбогдох журмын дагуу явуулж, хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниудад хурлын холбогдох материалыг баталгаат шуудан, МХБ-ийн цахим хуудсанд бүртгэлтэй байгаа цахим шуудангийн хаягаар нь pdf хэлбэрээр илгээсэн.

Тус хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2022 оны 03-р сарын 11-ний өдрийн 06/2022 тоот тогтоолоор гаргасан. Хурлын мэдэгдлийг тогтоосон хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсэн. Мөн хурлын мэдэгдлийг МХБ-ийн цахим хуудсан дээрх “Хархорин” ХК-ийн мэдээлэл хэсэгт байршуулсан.

Хурлыг зарлан хуралдуулах ажлыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу хийсэн болно.

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
2. Компанийн 2021 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг батлах.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох.
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.

Саналын хуудас хэрэглэсэн эсэх, саналын хуудасны загвар: “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03-р сарын 11-ний өдрийн 06/2022 тоот тогтоолын хавсралтаар компанийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн ээлжит хуралд хэрэглэх саналын хуудасны загварыг баталж тус саналын хуудсаар санал хураалт явуулсан болно (Компанийн тухай хуулийн 71.1-ийн дагуу).

Хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо, гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол:

Асуудал 1: Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

1-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,053; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0. Хүчингүй саналын хуудас гараагүй болно.

1-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол: “Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгож компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай гэж үзсэн болно.

Асуудал 2: Компанийн 2021 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

2-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,053; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0. Хүчингүй саналын хуудас гараагүй болно.

2-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол: “Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгож компанийн 2021 оны жилийн санхүүгийн тайлангийн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай гэж үзсэн болно.

Асуудал 3: Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг батлах тухай

3-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,053; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0. Хүчингүй саналын хуудас гараагүй болно.

3-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол: “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02-р сарын 18-ний өдрийн 04/2022 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-г удирдлага болгоод “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компани нь 2021 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт 43,059.3 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбогдуулан 2022 онд ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвшөөрөв.

Асуудал 4: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох тухай.

Тухайн асуудлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Ганбат танилцуулсан болно: Өнгөрсөн жил манай компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдээ сонгосон. Компанийн дүрмээр бол 4 жилийн хугацаатай ТУЗ-ийн гишүүдийг сонгодог. Иймд 2021 онд сонгогдсон гишүүд нь 2025 он хүртэл бүрэн эрх нь үргэлжлэхээр байгаа. Манай хувьцаа эзэмшигч “Селус номадс” ХХК нь нийт

хувьцааны 19 хувийг эзэмшдэг. Энэ удаагийн хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөө илгээнэ гэж байсан боловч хүрэлцэн ирсэнгүй. Тус хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн зүгээс ТУЗ-ийн гишүүн Лхагвасүрэнгийн Хосбаярын оронд төрсөн ах нь болох Лхагвасүрэнгийн Баяртулга орж ТУЗ-ийн гишүүнээр ажиллах саналыг гаргасан байгаа. Бусад гишүүд өөрчлөгдөөгүй. Иймд өнөөдрийн хурлаар одооны ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусаагүй байгаа, түүнчлэн кумулятив аргаар сонгосон тохиолдолд ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулж шинээр сонгодог тул эхлээд ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө огцруулах асуудлаар саналаа хураагаад, хэрвээ огцруулахаар болсон бол шинэ ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох болно.

4-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,053; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0. Хүчингүй саналын хуудас гараагүй болно.

4-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол: “Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас “Хархорин” нээлттэй хувьцаат компанийн 2021 оны 04-р сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 04-р тогтоолоор сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоор шийдвэрлэв.

Асуудал 5: Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.

5-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо:

ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо СЗХ-ны 2020 оны 880 дугаар тогтоолоор батлагдсан Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журмын дагуу тус хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн зүгээс ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд өгсөн кумулятив саналыг тус тусад нь тоолсон. Ердийн гишүүнд нэр дэвшиж байгаа 6 нэр дэвшигчдэд нийт 2,268,318 кумулятив санал ирсэн. Нэр дэвшигч тус бүрд өгсөн саналыг тоолж үзэхэд нэр дэвшигч тус бүрд 378,053 санал ирсэн.

Хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа 3 нэр дэвшигчдэд нийт 1,134,159 кумулятив санал ирсэн. Эдгээрийг нэр дэвшигч тус бүрээр тоолж үзэхэд хараат бус гишүүнд нэр дэвшигч тус бүр 378,053 санал авсан байсан. Ийнхүү саналаа өгсөн хувьцаа эзэмшигчид нь өөрсдийн кумулятив саналыг нийт 9 нэр дэвшигчдэд тэнцүү хуваарилж өгсөн байсан. Түдгэлзсэн санал гараагүй болно.

5-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол: Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-г удирдлага болгон “Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн:

Нэг. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр Сандагийн Амгалан, Баатарын Амарсанаа, Баттулгын Бүрэн нарыг томилов.

Хоёр. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Пүрэвийн Бишрэл, Пүрэвийн Учрал, Жаргалын Энхтөр, Лхагвасүрэнгийн Баяртулга, Цэрэндолгорын Энх-Амгалан, Ойдовсүрэнгийн Төмөрбаатар нарыг томилов.

Бусад асуудал хэлэлцсэн эсэх: бусад асуудал хэлэлцээгүй болно.

Хурал өндөрлөсөн: 15.50 цагт хурал өндөрлөсөн болно

Хурлаар шийдвэрлэсэн нь:

“Хархорин” нээлттэй хувьцаат компанийн 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас дараах шийдвэрүүдийг гаргасан болно. Үүнд:

1. “Хархорин” нээлттэй хувьцаат компанийн 2021 оны жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай гэж шийдвэрлэв.
2. “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компани нь 2021 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт 43,059.3 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбогдуулан 2022 онд ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвшөөрөв.
3. “Хархорин” нээлттэй хувьцаат компанийн 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 04 дүгээр тогтоолоор сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох.
4. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр Сандагийн Амгалан, Баатарын Амарсанаа, Баттулгын Бүрэн нарыг,
“Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Пүрэвийн Бишрэл, Пүрэвийн Учрал, Жаргалын Энхтөр, Лхагвасүрэнгийн Баяртулга, Цэрэндолгорын Энх-Амгалан, Ойдовсүрэнгийн Төмөрбаатар нарыг тус тус томилох.

ХУРЛЫН ДАРГА



Хурлын тэмдэглэл үйлдсэн

П.УЧРАЛ

Б.Ганбат